*Шүүх шинжилгээний ерөнхий газрын*
*2026 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн*
*03/133223 тоот албан бичгийн хоёрдугаар хавсралт*

# ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ДОТООД ХЯНАЛТ, АУДИТЫН ГАЗАР

## ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 25 Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын дагуу Шүүх шинжилгээний байгууллагын хэрэгжүүлж буй хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийлээ.

### *Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт*

Шүүх шинжилгээний ерөнхий газарт хамааралтай нэгдсэн системд байршуулсан Шүүх шинжилгээний тухай хуулийн 22 заалт, “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэл”-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний хүрээнд 2, “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл”-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний хүрээнд 1, "Эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилт" асуудлаар авах зарим арга хэмжээний хүрээнд 1, “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 2, “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай” ажлын хүрээнд 1, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 22 дугаар хуралдааны тэмдэглэл”-ийн хүрээнд 1 нийт 30 арга хэмжээний хэрэгжилтийг дүгнэлээ.

*Тогтоол шийдвэрийн биелэлтийг хүснэгтээр харуулбал:*

| № | Арга хэмжээ | Заалтын тоо | Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Хэрэгжсэн | Хэрэгжээгүй | Хугацаа болоогүй |
| 1 | Шүүх шинжилгээний тухай<br>2022-12-23<br>Дугаар 2022.12.23 | 22 | 22 | - | - |
| 2 | Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэл”-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээ | 2 | 2 | - | - |
| 3 | “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл”-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээ | 1 | 1 | - | - |
| 4 | "Эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилт" асуудлаар авах зарим арга хэмжээ | 1 | 1 | - | - |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 5 | “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 2025-05-14 Дугаар 2025№01 АБГББХ | 1 | 1 | - | - |
| 6 | “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 2019-05-30 Дугаар 2019_104 | 1 | 1 | - | - |
| 7 | “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай” 2018-02-05 Дугаар 2018_06/05 | 1 | 1 | - | - |
| 8 | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 22 дугаар хуралдааны тэмдэглэл | 1 | 1 | - | - |
| **Нийт** | | **30** | **30** | **-** | **-** |

*(Төлөвлөгөөний биелэлтийг хавсралтаас үзнэ үү.)*

## ДҮГНЭЛТ

Шүүх шинжилгээний ерөнхий газарт хамааралтай нэгдсэн сестемд байршуулсан хууль тогтоомж, тогтоол шийдвэр хэрэгжсэн байна.

________оОо________

# ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

(2025 оны жилийн эцсийн байдлаар)

| Шийдвэрийн д/д | Заалтын д/д | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Холбогдох заалтын агуулга | Хэрэгжилтын явц | Үр нөлөө | Нотломж | Үнэлгээний тайлбар | Хяналтаас хасах саналтай эсэх | Хяналтаас хасах санал |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 50 | | 11.12.1.мэдээллийн сан үүсгэх, мэдээллийн санг нийтэд танилцуулах, шинжээчийн хувийн дугаар бүхий тэмдэг, маягт ашиглах журам; | Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/267 дугаар тушаалаар "Мэдээллийн сан үүсгэх, мэдээллийн санг нийтэд танилцуулах", "Шинжээчийн хувийн дугаар бүхий тэмдэг, маягт ашиглах журам", "Шинжээчийн хувийн дугаар бүхий тэмдгийн загвар", "Шинжээчийн дүгнэлтийн маягтын загвар", "Шинжилгээний байгууллагын шинжээчийн дүгнэлтийн маягтын загвар", "Сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэл тогтоосныг хүлээн зөвшөөрсөн маягтын загвар"-ыг баталсан.<br>/Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2023.08.09-ний өдөр 6338 дугаарт бүртгэгдсэн/ | Шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах иргэн цахим хэлбэрээр хүсэлт гаргах, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгосон талаарх мэдээллийн санг үүсгэх, нийтэд танилцуулахтай холбоотой харилцааг зохицуулсан.<br>Журам, загвар батлагдсанаар шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгогдсон шинжээчийн тухай нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх, шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд болон олон нийтийг мэдээллээр хангах, шинжээч нар улсын хэмжээнд нэгдсэн загварын тэмдэг, дүгнэлтийн маягт хэрэглэх үндэс болох юм. | Батлагдсан журмыг цахим (pdf) хэлбэрээр хавсаргасан. | 100 | | |
| | 51 | | 11.12.2.зөвлөлийн үйл ажиллагааны журам; | Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн А/158 дугаар тушаалаар "Тусгай мэдлэг бүхий хүнд шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, сунгах, хүчингүй болгох санал, дүгнэлт гаргах эрх бүхий орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ыг баталсан.<br>/Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2023.06.22-ны өдөр 6259 дугаарт бүртгэгдсэн/<br>"Журамд өөрчлөлт оруулах тухай" Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн А/331 дүгээр тушаал батлагдаж, 16 гишүүнтэй болж, 30-аас доошгүй хувь нь шүүх шинжилгээний туршлагатай, 70-аас доошгүй хувь нь эрдмийн зэрэг, цолтой байхаар заасан.<br>Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн А/349 дүгээр тушаалаар "Тусгай мэдлэг бүхий хүнд шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, сунгах, хүчингүй болгох санал, дүгнэлт гаргах эрх бүхий орон тооны бус зөвлөлийг байгуулж, бүрэлдэхүүн"-ийг баталсан. | Журамд орон тооны бус Зөвлөлийн дарга, Ажлын албаны дарга, гишүүн, ажлын албаны чиг үүргийг нарийвчлан тусгасан бөгөөд комисс томилж, иргэдийн баримт бичиг хянан магадлагаа хийх, комиссын саналыг Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, тогтоол батлах зэрэг асуудлуудыг тусгасан бөгөөд тусгай мэдлэг бүхий мэдлэг, боловсролтой иргэдээр шинжилгээ хийлгэх, төрийн байгууллагын ачааллыг бууруулах, төрийн зарим чиг үүргийг хувийн байгууллагаар хэрэгжүүлэх олон талын үр нөлөөтэй. | Батлагдсан журмыг цахим (pdf) хэлбэрээр хавсаргасан. | 100 | | |
| | 52 | | 11.12.3.шинжээчийн хувийн дугаар бүхий тэмдэг, дүгнэлтийн маягтын загвар. | Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/267 дугаар тушаалаар "Мэдээллийн сан үүсгэх, мэдээллийн санг нийтэд танилцуулах", "Шинжээчийн хувийн дугаар бүхий тэмдэг, маягт ашиглах журам", "Шинжээчийн хувийн дугаар бүхий тэмдгийн загвар", "Шинжээчийн дүгнэлтийн маягтын загвар", "Шинжилгээний байгууллагын шинжээчийн дүгнэлтийн маягтын загвар", "Сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэл тогтоосныг хүлээн зөвшөөрсөн маягтын загвар"-ыг баталсан. | Журам, загвар батлагдсанаар шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгогдсон шинжээчийн тухай нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх, шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд болон олон нийтийг мэдээллээр хангах, шинжээч нар улсын хэмжээнд нэгдсэн загварын тэмдэг, дүгнэлтийн маягт хэрэглэх үндэс болох юм. | Батлагдсан загварыг цахим (pdf) хэлбэрээр хавсаргасан. | 100 | | |
| | 53 | | 14.9.Хими, физик, биологи, дезоксирибонуклейны хүчил /ДНХ/, бактериологийн зэрэг лабораторийн шинжилгээ хийх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. | Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн А/227 дугаар тушаалаар "Химийн шинжилгээ хийх журам", "Физикийн шинжилгээ хийх журам", "Биологийн шинжилгээ хийх журам", "Дезоксирибонуклейн хүчил /ДНХ/-ын шинжилгээ хийх журам", "Бактериологийн шинжилгээ хийх журам"-ыг баталсан.<br>/Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2023.07.07-ны өдөр 6297 дугаарт бүртгэгдсэн/ | Эрүүгийн, иргэний, захиргааны, арбитрын хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх, зөрчлийн хэргийг шалган шийдвэрлэх ажиллагааны явцад хими, физик, биологи, ДНХ, бактериологийн шинжилгээ хийх арга, аргачлал, лабораторийн ажиллагаа, нууцлал, аюулгүй байдлыг зохицуулсан. | Батлагдсан журмыг цахим (pdf) хэлбэрээр хавсаргасан. | 100 | | |
| | 54 | | 32.4.Криминалистикийн шинжилгээ хийх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. | Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А/206 дугаар тушаалаар "Криминалистикийн шинжилгээ хийх журам"-ыг баталсан.<br>/Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2023.06.22-ны өдөр 6260 дугаарт бүртгэгдсэн/ | Криминалистикийн шинжилгээ хийх нийтлэг үндэслэл, нэр томьёоны тодорхойлолт, шинжилгээний объект, харьцуулах загвар, түүнд тавигдах шаардлага, шинжилгээ хийх арга, хэрэгсэл, шинжилгээ хийх нөхцөлийг тодорхойлох, шинжээчийн дүгнэлт, шинжилгээний явц үр дүнг тусгасан үзүүлэлт, түүнд тавигдах шаардлага, шинжээчийн шинжилгээ хийх үйл ажиллагааг нарийвчлан зохицуулсан. | Батлагдсан журмыг цахим (pdf) хэлбэрээр хавсаргасан. | 100 | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 55 | | 33.9.Шүүх эмнэлгийн шинжилгээ хийх журам, хүний эрүүл мэндэд учирсан хохирлын зэрэг тогтоох журмыг эрүүл мэнд болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Улсын ерөнхий прокурортой хамтран батална. | Эрүүл мэндийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын ерөнхий прокурорын 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн А/259, А/173, А/94 дугаартай хамтарсан тушаалаар "Шүүх эмнэлгийн шинжилгээ хийх журам"-ыг баталсан. /Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2024.06.12-ны өдөр 6867 дугаарт бүртгэгдсэн/.<br>Эрүүл мэндийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын ерөнхий прокурорын 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн А/225, А/153, А/85 дугаартай хамтарсан тушаалаар "Хүний эрүүл мэндэд учирсан хохирлын зэрэг тогтоох журам"-ыг баталсан. /Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2024.06.11-ний өдөр 6864 дугаарт бүртгэгдсэн/. | Шүүх эмнэлгийн шинжилгээний журамд шинжилгээний обьект тус бүрээр шинжлэх үйл ажиллагаа Шүүх шинжилгээний хуулийн зүйл заалттай уялдуулсан ба Хууль зүйн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2014 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/216/422 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан<br>"Цогцост шинжилгээ хийх журам"-тай хамтатган боловсруулахын зэрэгцээ шүүх эмнэлгийн шинжилгээг багаар хийх онцлог, шинжилгээ хийхэд баримтлах стандарт, цогцост дүрслэл оношилгооны шинжилгээ хийх шинэ арга аргачлалын талаарх зохицуулалтыг тусгасан.<br>Хүний эрүүл мэндийн хохиролын зэргийг бодитой, үндэслэлтэй тогтоох нь маш чухал бөгөөд уг журамд зүйл, заалтын талаар эмнэл зүйг тусган, зураг, хүснэгтийг дэлгэрүүлэн тайлбарласан аргачлалыг шинжээч эмч, мөрдөгч, прокурор, шүүгч, өмгөөлөгч болон бусад эрх бүхий албан тушаалтан нарт зориулан боловсруулж, салаа утга санаа агуулсан, тодорхойгүй зүйлийг оновчтой томъёолсон. | Батлагдсан журмыг цахим (pdf) хэлбэрээр хавсаргасан. | 100 | | | |
| | 56 | | 34.4.Эдийн засгийн шинжилгээ хийх журмыг хууль зүйн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална. | Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын 2023 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн А/314 А/178 дугаар хамтарсан тушаалаар "Эдийн засгийн шинжилгээ хийх журам"-ыг баталсан. | Эрүүгийн, иргэний, захиргааны, арбитрын хэрэг, маргаан хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад эрх бүхий байгууллагаас гаргасан акт, дүгнэлт, тусгай мэдлэг бүхий мөрдөгчийн магадлагаа нь тухайн хэргийг шийдвэрлэхэд хангалттай үндэслэл болж чадахгүй байгаа, үнэн зөв, бодитой эсэх нь эргэлзээтэй, эсхүл үнэн зөв бодитой тодорхойлж чадаагүй, буруу гэдгийг холбогдох этгээд тодорхой баримтаар нотолсон тохиолдолд эдийн засгийн шинжилгээ хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргах үйл ажиллагааг зохицуулсан нь чухал ач нөлөөтэй юм. | Батлагдсан журмыг цахим (pdf) хэлбэрээр хавсаргасан. | 100 | | | |
| | 57 | | 35.3.Хөрөнгийн үнэлгээний шинжилгээ хийх журмыг хууль зүйн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална. | Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын 2023 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн А/264 А/154 дүгээр хамтарсан тушаалаар "Хөрөнгийн үнэлгээний шинжилгээний журам"-ыг баталсан.<br>/Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2023.08.31-ний өдөр 6388 дугаарт бүртгэгдсэн/ | Эрүүгийн, иргэний, захиргааны, арбитрын хэрэг, маргаан хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад хөрөнгийн үнэлгээний тайлан гарсан байна. Хөрөнгийн үнэлгээний тайлан нь тухайн зүйлийн шинж байдал, онцлогт үндэслээгүй, үнэлгээний стандарт, дүрэм, журам, норм, нормативыг зөрчсөн, хөрөнгийн үнэлгээний зүйлийн тогтоосон үнэ, цэнэ үндэслэлгүй, бодитой бус, тодорхой бус байх тохиолдолд хөрөнгийн үнэлгээний шинжилгээ хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргах үйл ажиллагааг зохицуулсан. | Батлагдсан журмыг цахим (pdf) хэлбэрээр хавсаргасан. | 100 | | | |
| | 58 | | 36.4.Цахим технологийн шинжилгээ хийх журмыг хууль зүйн болон цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална. | Хууль зүй, дотоод хэргийн сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн А/315 А/91 дүгээр хамтарсан тушаалаар "Цахим технологийн шинжилгээ хийх журам"-ыг баталсан.<br>/Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2023.09.14-ний өдөр 6412 дугаарт бүртгэгдсэн/ | Шинэ тутамд хөгжиж буй цахим технологийн шинжилгээний ангилал, шинжилгээний төрлийг нарийвчлан тодорхойлж өгөхийн зэрэгцээ шинжилгээний онцлогт тулгуурласан шинжилгээ хийх үйл ажиллагаа сайжирч, шинжээчийн дүгнэлт хэрэг маргааныг шийдвэрлэхэд чухал ач холбогдол бүхий нотлох баримтын эх сурвалж болох хууль эрх зүйн үндэслэл бүрэлдсэн юм. | Батлагдсан журмыг цахим (pdf) хэлбэрээр хавсаргасан. | 100 | | | |
| 25 | 59 | Шүүх шинжилгээний тухай 2022-12-23 | 37.7.Инженер-техникийн шинжилгээ хийх журмыг холбогдох асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. | Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А/334 дүгээр тушаалаар "Инженер-техникийн шинжилгээ хийх журам"-ыг баталсан.<br>/Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2023.10.06-ны өдөр 6443 дугаарт бүртгэгдсэн/ | Эрүү, иргэн, захиргаа, арбитрын хэрэг маргааныг хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад инженерийн байгууламж, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, бүтээгдэхүүнд чанарын болон тоон технологийн өөрчлөлт байгаа эсэх, үүссэн нөхцөл байдлын шалтгаан нөхцөлийг тогтоохоор инженер-техникийн шинжилгээ хийж, дүгнэлт гаргахтай холбогдсон харилцааг зохицуулсан. | Батлагдсан журмыг цахим (pdf) хэлбэрээр хавсаргасан. | 100 | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 60 | Дугаар 2022.12.23 | 38.10.Хүрээлэн байгаа орчны хохирлын үнэлгээ, шинжилгээ хийх журмыг хууль зүйн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална. | Хууль зүй, дотоод хэргийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн А/303 А/308 дугаар хамтарсан тушаалаар "Хүрээлэн байгаа орчны хохирлын үнэлгээ, шинжилгээ хийх журам"-ыг баталсан. | Журамд батлагдсанаар амьтан судлалын шинжилгээ (ангилал зүй, нас, хүйс, статус, экологи эдийн засгийн үнэлгээ, тархац нутаг), мод судлалын шинжилгээ (ангилал зүй, насжилт, чийг, статус, эзлэхүүн /м3/, экологи-эдийн засгийн үнэлгээ /мужлал/), ургамал судлалын шинжилгээ (ангилал зүй, статус, чийг, экологи эдийн засгийн үнэлгээ, тархац нутаг), хөрсний шинжилгээ (хөрсний чийг, температур тодорхойлох, хөрсний даралт нэвтрүүлэх чадвар, хөрсний орчин /PH/ тодорхойлох, хөрсний зарим хүнд металл), усны шинжилгээ (усанд уусан хүчилтөрөгчийн хэмжээ, усны хурд, температур тодорхойлох, усны орчинг тодорхойлох, усны цахилгаан дамжуулах чанар, усанд уусан хатуу бодисын хэмжээ), бусад шинжилгээ (агаарт 16 төрлийн хий, PM2.5, PM10, TVOC агууламж тодорхойлох, дуу чимээний түвшин хэмжих, эвдэрсэн газрын хэмжээ, ургамлын бүрхэвч, нөлөөллийн бүсийг тогтоох, зураглал гэх мэт) шинжилгээ хийх эрх зүйн үндэс бүрдэж, байгаль орчинд учруулсан экологи, эдийн засгийн хохирлын үнэлгээг тооцох нөхцөл бүрдсэн. | Батлагдсан журмыг цахим (pdf) хэлбэрээр хавсаргасан. | 100 | | | |
| 61 | | 39.8.Сэтгэцийн шинжилгээ хийх журмыг хууль зүйн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална. | Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/269 А/276 дугаар хамтарсан тушаалаар "Сэтгэцийн шинжилгээ хийх журам"-ыг баталсан.<br>/Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2023.08.22-ны өдөр 6345 дугаарт бүртгэгдсэн/ | Нийгмийн хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн шинжилгээ хийхэд тавигдах нийтлэг шаардлага, шинжээч эмчийн эрх, үүрэг, шинжилгээний хэлбэр, иргэний хэрэгт сэтгэцийн шинжилгээ хийх, шинжилгээний зардал болон хариуцлага зэргийг тусгасан. | Батлагдсан журмыг цахим (pdf) хэлбэрээр хавсаргасан. | 100 | | | |
| 62 | | 40.3.Энэ хуулийн 40.1-д заасан дүгнэлт гаргах журмыг хууль зүйн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална. | Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/268 А/275 дугаар хамтарсан тушаалаар "Гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргах журам", "Тухайлсан гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоох хүснэгт"-ийг баталсан.<br>/Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2023.08.08-ны өдөр 6337 дугаарт бүртгэгдсэн/<br>Монгол Улсын Дээд шүүхийн нийт шүүгчийн 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн 25 дугаар тогтоолоор "Хүний сэтгэцэд учирсан хор уршгийг арилгах, нөхөн төлүүлэх төлбөрийн жишиг аргачлал"-ыг баталсан. | Энэхүү журмаар шинэ төрлийн шинжилгээ хийхтэй холбоотой харилцааг зохицуулсан бөгөөд Эрүүгийн хуулийн 14 бүлгийн 85 гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргах, хүний эрх, эрх чөлөөг хангах, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллахад чухал үр нөлөөтэй. | "Гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргах журам", "Тухайлсан гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг | 100 | | | |
| 63 | | 43.3.Яллагдагч, шүүгдэгчийг эрүүл мэндийн байгууллагад байрлуулах журмыг хууль зүйн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална. | Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн А/239 А/244 дүгээр хамтарсан тушаалаар "Яллагдагч, шүүгдэгчийг эрүүл мэндийн байгууллагад байрлуулах журам"-ыг баталсан. | Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдуулан хуулийн шинэ нэр томьёо үзэл баримтлалыг журамд тусгасан бөгөөд эрүүгийн хэрэг маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны явцад яллагдагч, шүүгдэгчийг эрүүл мэндийн байгууллагад байрлуулах үйл ажиллагааг зохицуулсан. | Батлагдсан журмыг цахим (pdf) хэлбэрээр хавсаргасан. | 100 | | | |
| 64 | | 52.2.Шинжилгээний байгууллагын туг, бэлгэ тэмдгийн загвар болон хэрэглэх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. | Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн А/93 дугаар тушаалаар "Шүүх шинжилгээний байгууллагын бэлгэ тэмдгийн тодорхойлолт, хэрэглэх журам", "Шүүх шинжилгээний байгууллагын бэлгэ тэмдгийн загвар", "Шүүх шинжилгээний байгууллагын тугны тодорхойлолт, хэрэглэх журам", "Шүүх шинжилгээний байгууллагын тугны загвар"-ыг баталсан. | Шүүх шинжилгээний байгууллага нь нэгдсэн зохион байгуулалтаар үйл ажиллагаа явуулснаас хойш эрхэлсэн ажлын онцлог, түүхэн уламжлалыг илэрхийлсэн бэлгэдэлгүй, байгууллагын туг, бэлгэ тэмдэг хэрэглэх харилцааг зохицуулсан эрх зүйн актгүй байсан тул холбогдох журмыг батлуулснаар байгууллагын туг, бэлгэ тэмдгийн загвар, хэрэглэх, хадгалах, хамгаалах, зөөвөрлөх, хүлээлгэн өгөх, оёх, засварлахтай холбоотой харилцааг зохицуулсан. | Батлагдсан журмыг цахим (pdf) хэлбэрээр хавсаргасан. | 100 | | | |
| 65 | | 56.7.Шинжилгээний байгууллагын алба хаагчийн мэргэжлийн түвшинг тогтоох шалгалт авах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. | Хууль зүй дотоод хэргийн сайдын 2023 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн А/251 дүгээр тушаалаар "Шинжилгээний байгууллагын алба хаагчийн мэргэжлийн түвшин тогтоох шалгалт авах журам"-ыг баталсан. | Шүүх шинжилгээний байгууллагын алба хаагчдын мэргэжлийн түвшнийг тогтоох, зэрэг олгох шалгалт авах, үйл ажиллагааны үр дүнг үнэлж, дүгнэх болон тэдгээртэй холбогдох бусад харилцааг зохицуулснаар мэргэшсэн, чадварлаг, ёс зүйтэй хүний нөөцийг бүрдүүлэхэд ач холбогдолтой юм. | Батлагдсан журмыг цахим (pdf) хэлбэрээр хавсаргасан. | 100 | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 66 | | 62.2.Шинжилгээний байгууллагын алба хаагчийг албан тушаал дэвшүүлэх, бууруулах, өөр албан тушаалд шилжүүлэн томилох журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. | Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн А/354 дүгээр тушаалаар "Шүүх шинжилгээний байгууллагын алба хаагчийг албан тушаал дэвшүүлэх, бууруулах, өөр албан тушаалд шилжүүлэн томилох журам"-ыг баталсан. | Энэхүү журам батлагдахаас өмнө Шүүх шинжилгээний байгууллага нь алба хаагчийг албан тушаал дэвшүүлэх, бууруулах, өөр албан тушаалд шилжүүлэн томилохтой холбоотой харилцааг зохицуулсан тусгайлсан журамгүй байсан.<br>Журам батлагдсанаар төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг хангаж, чадахуйн зарчимд суурилсан хүний нөөцийг бүрдүүлэх, алба хаагчдын манлайллыг дээшлүүлэхэд чухал ач холбогдол бүхий эрх зүйн баримт бичиг болсон. | Батлагдсан журмыг цахим (pdf) хэлбэрээр хавсаргасан. | 100 | | |
| | 67 | | 64.8.Албан үүргийг түр орлон гүйцэтгэх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. | Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн А/299 дүгээр тушаалаар "Шинжилгээний байгууллагын алба хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журам"-ыг баталсан. | Энэхүү журам батлагдахаас өмнө Шүүх шинжилгээний байгууллага нь алба хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх харилцааг зохицуулсан тусгайлсан журамгүй байсан.<br>Журам батлагдсанаар байгууллагын үйл ажиллагаа тасралтгүй хэвийн явуулах нөхцөл боломжийг бүрдүүлсэн. | Батлагдсан журмыг цахим (pdf) хэлбэрээр хавсаргасан. | 100 | | |
| | 68 | | 65.2.Шинжилгээний байгууллагын ажилтны сахилгын дүрмийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. | Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А/181 дүгээр тушаалаар "Шүүх шинжилгээний байгууллагын алба хаагчийн сахилгын дүрэм"-ийг баталсан. | Байгууллагын үнэт зүйл, соёл бий болж, алба хаагчдад хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээг нэгтгэх, хариуцлага хүлээлгэх үндэслэлийг тодорхой болгох, алба хаагч, ажилтны хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалж, шударга ёсыг бэхжүүлэх, хандлага, хариуцлагыг дээшлүүлэхэд чухал ач холбогдол бүхий эрх зүйн баримт бичиг болсон. | Батлагдсан дүрмийг цахим (pdf) хэлбэрээр хавсаргасан. | 100 | | |
| | 69 | | 71.3.Энэ хуулийн 71.2-т заасан мөнгөн тэтгэмж олгох журмыг Засгийн газар батална. | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 99 дугаартай тогтоолоор "Аймаг, сумын нутаг дэвсгэр хариуцсан шүүх шинжилгээний байгууллагын алба хаагчид мөнгөн тэтгэмж олгох журам"-ыг баталсан. | Төрөөс хэрэгжүүлж буй нийслэл хот дахь хүн амын төвлөрлийг сааруулах, орон нутагт шилжин суурьших иргэдийг дэмжих, хот, хөдөөгийн сэргэлтийг эрчимжүүлэх бодлогын хүрээнд аймаг, орон нутагт ажиллаж буй тус байгууллагын алба хаагчдын нийгэм, эдийн засгийн баталгааг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах, албандаа хандах хандлага, итгэл үнэмшил, хариуцлагыг нэмэгдүүлэх, ажлын бүтээмж, үр дүнг сайжруулахад чухал үр нөлөөтэй юм. | Батлагдсан журмыг цахим (pdf) хэлбэрээр хавсаргасан. | 100 | | |
| | 70 | | 71.11.Энэ хуулийн 71.6-д заасан зардлыг Засгийн газар хариуцан гаргаж, гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх бөгөөд энэ хуулийн 71.8-д заасан нөхөх олговор, тусламж олгох журам, 71.10-т заасан зардал олгох журмыг Засгийн газар батална. | ШШГЕ-аас 2023.04.04-ний өдөр 01/2280 дугаар албан бичгээр ХЗДХЯ-нд хүргүүлж, СХОГ-аас төслийг ХНХЯ-нд хүргүүлсэн.<br>ХНХЯ-наас 2023.07.25-ны өдрийн 01/1916 дугаартай албан бичгээр "төслүүд нь Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль болон Засгийн газрын 2019 оны 6, 8 дугаар тогтоолуудтай зохицуулалтын хувьд давхардаж, Захиргааны ерөнхий хуулийн 60 дахь хэсэг заасан захиргааны хэм хэмжээний актад тавих шаардлагатай зөрчилдөж байх тул шинээр батлах шаардлагагүй" гэж хариуг ирүүлсэн тул зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байна. | ХНХЯ-наас ирүүлсэн албан бичгийг цахим (pdf) хэлбэрээр хавсаргасан. | 100 | | |
| | 71 | | 75.6.Энэ хуулийн 75.2-т заасан хугацаа сунгах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. | Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/228 дугаар тушаалаар "Шинжилгээний байгууллагын алба хаагчийн алба хаах хугацаа сунгах журам"-ыг баталсан. | Энэхүү журам батлагдахаас өмнө Шүүх шинжилгээний байгууллага нь алба хаах насны дээд хязгаарт хүрсэн алба хаагчийн алба хаах хугацааг сунган ажиллуулахтай холбоотой харилцааг зохицуулсан тусгайлсан журамгүй байсан бөгөөд журам батлагдсанаар уг харилцааг илүү нарийвчлан зохицуулсан. | Батлагдсан журмыг цахим (pdf) хэлбэрээр хавсаргасан. | 100 | | |
| | | | 1.2/а/.2/Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын | "Гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргах журам"-ын хэрэгжилтэд гарч буй тулгамдсан асуудал, цаашид хэрэгжүүлэх ажлын саналыг 2025 оны 01/10887, 01/12240 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэн ажилласан. | | | | | |
| | | | | Тус газрын Шүүх сэтгэцийн шинжилгээний тасаг тайлант хугацаанд хүүхдийн эсрэг гэмт хэрэг, хүүхдийн бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч бүхий 465 хүүхдэд гэмт хэргийн улмаас сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэл тогтоох шинжилгээг батлагдсан аргачлалын дагуу хийж гүйцэтгэсэн. | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 34 | 91 | Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2019-06-06 Дугаар 2019 №62 | талаар: а/хүүхдийн эсрэг гэмт хэрэг, хүүхдийн бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч хүүхдийн сэтгэл санааны гэм хорыг үнэлэх, тооцох аргачлалыг боловсруулж хэрэгжүүлэх; | **Алба хаагчдыг чадавхжуулсан байдал:** Оросын Холбооны Улсад ашиглагдаж буй сэтгэл зүйн шинжилгээний орчин үеийн дэвшилтэт тоног төхөөрөмж, арга аргачлалтай танилцаж, туршлага судлах зорилгоор тус улсын Хууль зүйн яамны харьяа Холбооны шүүх эмнэлгийн төвд 2025 оны 03 дугаар сард зохион байгуулагдсан "Сэтгэл зүйн шинжилгээ" сэдэвт сургалтад тус газрын 3 алба хаагч хамрагдсан. | | | | | |
| | | | | Мөн тус улсад хүний сэтгэл зүйн төлөв, физиологийн хариу урвалыг судлан, практикт үр дүнтэй ашиглах, полиграфын орчин үеийн арга, технологийн хэрэглээ, шинжилгээний арга зүй, мэдээлэл боловсруулах үндсэн зарчмуудын талаар туршлага солилцох зорилгоор Оросын Холбооны Улсын Дотоод хэргийн яамны харьяа В.Я.Кикотягийн нэрэмжит Москвагийн их сургуульд 2025 оны 10 дугаар сард зохион байгуулагдсан "Полиграф ашиглан хүний бие, сэтгэл зүйн төлөв байдлыг тодорхойлох нь" сэдэвт сургалтад 3 алба хаагч амжилттай хамрагдсан. | Гэмт хэргийн хохирогч хүүхдийн сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэл тогтоох шинжилгээг батлагдсан аргачлалын дагуу хийснээр тухайн хүүхдэд ямар төрлийн сэтгэл зүйн дэмжлэг, заслын үйлчилгээ үзүүлэх аргыг тогтоож, улмаар сөрөг мэдрэмжийг өөрчлөх, дахин хохирогч болохоос урьдчилан сэргийлэх, шаардлагатай тусламж үйлчилгээнд холбож зуучлахад ач холбогдолтой юм. | Санал хүргүүлсэн албан бичгийг цахим (pdf) хэлбэрээр хавсаргасан. Холбоос линк: https://nfa.gov.mn/site/single/424 https://nfa.gov.mn/site/single/270 | 100 | | |
| | 92 | | 1.2/в/.хүүхдийн эсрэг гэмт хэрэг, хүүхдийн бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогчийн нийгэм, сэтгэлзүйн нөхөн сэргээх үйлчилгээнд гарч байгаа зардлыг төр бүрэн хариуцдаг байх, хохирогчийг дэмжих сан байгуулахад анхаарах; | Тус газрын "Нэг цэгийн үйлчилгээний төв" нь гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн холбогдолтой гэмт хэргийн хохирогч, бага насны хүүхэд, жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчдийн эрх ашгийг хамгаалах хүрээнд үзлэгийн өрөөг тохижуулан сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ үзүүлж байна.<br>Тайлант хугацаанд "Нэг цэгийн үйлчилгээний төв"-д тус газрын Шүүх сэтгэцийн шинжилгээний тасагт шинжилгээ хийлгэсэн 90 иргэн, сайн дураар хандсан 9 иргэн, давхардсан тоогоор 99 иргэнд сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ үзүүлсэн байна. Үйлчлүүлсэн иргэдийн 19 эрэгтэй, 80 эмэгтэй, насны байдлаар авч үзвэл 0-18 насны 20 хүүхэд, 18-аас дээш насны 79 үйлчлүүлэгч байна. Үүнээс гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 0-17 насны 8, бэлгийн хүчирхийлэлд өртсөн 0-17 насны 9, бусад шалтгаанаар 3 хүүхдэд тусламж үзүүлж ажилласан. | | | | | |
| | | | | "Нэг цэгийн үйлчилгээний төв"-өөр үйлчлүүлж буй иргэдийн стресс тайлах, өмнө тохиолдож байсан тавгүй дурсамжтайгаа нүүр тулах, сэтгэлийн хямрал, түгшүүр, нойргүйдлийг эмчлэх зорилгоор VR төхөөрөмж болон Альфа-стим аппарат, анхан шатанд булчингийн чангарал болон түгшилтийг бууруулах элсэн засал, тайвшруулах, цочролоос үүссэн булчингийн хатуурал, зангиралтаас урьдчилан сэргийлэх, бие организмын эрхтэн тогтолцоонд эерэг нөлөө үзүүлэх зорилгоор массажны сандал болон хүчилтөрөгчийн коктейл бэлтгэх зэргийг сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаандаа ашиглаж байна. | Гэмт хэргийн хохирогч болсон хүүхдүүд амьдралынхаа турш сэтгэл зүйн гэмтэлтэй болдог тул сэтгэл зүйн хувьд эдгээж, хүлээн зөвшөөрч амьдрахад урт хугацааны мэргэжлийн хүний туслалцаа, дэмжлэг шаардлагатай гэж үздэг. Нэг цэгийн үйлчилгээний төвд сэтгэцийн шинжилгээнд орсон хүчирхийллийн хохирогч хүүхэд, тэдний гэр бүл бүрд сэтгэл зүйн зөвлөгөө, сэтгэл заслын үйлчилгээг санал болгодог бөгөөд хүчирхийллийн дараах сэтгэл зүйн үйлчилгээ нь сэтгэл гутрал түгшлийг бууруулах, танин мэдэхүй, зан үйлийн өөрчлөлт, цаашдын эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлж хийгддэг үйлчилгээ юм.<br>Энэ нь тухайн таагүй бодол мэдрэмж хүчтэй бий болох үед түүнийгээ илэрхийлж гадагшлуулах, өөрийн сэтгэл санаа, биед үүсэж байгаа мэдрэмжээ зохицуулж сургахад чухал үр нөлөөтэй юм. | Үйл ажиллагаатай статистик мэдээг цахим (pdf) хэлбэрээр хавсаргасан. | 100 | | |
| 85 | 286 | "Монгол Улс | | Тус газрын Шүүх анагаах ухааны шинжилгээний газрын Шүүх эмнэлгийн амбулаторийн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Ө.Сарангэрэл нь бага насны хохирогч, хүүхдийн эрхийг хамгаалах хүрээний үйл ажиллагаа, сургалт, хэлэлцүүлгийг хариуцан ажиллаж байна.<br>Байгууллагын хэмжээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар 0-17 насны 4541 хүүхэд гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ, бэлгийн маргаантай 1054 хүүхэд үзлэг, шинжилгээ хийж, дүгнэлт гарган ажилласан байна.<br>"Нэг цэгийн үйлчилгээний төв"-д хандсан 99 иргэнд сэтгэл зүй, эрүүл мэнд болон холбон зуучлах үйлчилгээ үзүүлж ажилласан. Үүнээс гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 0-17 насны 8, бэлгийн хүчирхийлэлд өртсөн 0-17 насны 9, бусад шалтгаанаар 3 хүүхэд сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ үзүүлж ажиллалаа. | | Үйл ажиллагаатай статистик мэдээг цахим (pdf) хэлбэрээр хавсаргасан.<br><br>Холбоос линк: https://www.facebook.com/share/p/1CRbjAA7b6/?mibextid=WaXdOe<br><br>https://www.facebo | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл"-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2018-01-31 Дугаар 2018 №02 ХЗБХ | 3.10.Бага насны хохирогч хүүхдийн эрхийг хамгаалахад мэргэшсэн өмгөөлөгч, нарийн мэргэшсэн шүүхийн шинжилгээний шинжээч, хүүхдийн асуудал хариуцсан мөрдөгч ажиллуулах. | Бусад ажлын талаар: Монголын эх барих эмэгтэйчүүдийн эмч нарын холбооноос 2025 оны 02 дугаар сард зохион байгуулсан "Эх барих эмэгтэйчүүдийн эмчийн резидентийн хөтөлбөр"-т бэлгийн хүчирхийлэлд өртөгсдөд үзүүлэх эмнэл зүйн тусламж үйлчилгээний талаарх уулзалт, ярилцлагад д/х Ө.Сарангэрэл нь оролцож, санал хүргүүлэхээс гадна 2025 оны 03 дугаар сард резидент эмч нарт "Биеийн ерөнхий болон бэлэг эрхтний үзлэг, пиктограмм, баримтжуулалт" сэдэвт сургалтыг зохион байгуулсан.Хүүхдээс үйлдсэн болон хүүхдийн эсрэг үйлдсэн гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, аливаа гэмт хэргийн хохирогч болсон хүүхдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр тодорхой ажил, арга хэмжээг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тус газрын д/х Ө.Сарангэрэл томилогдсон бөгөөд 2025 оны 04 дүгээр сард цахим хурал, 05 дугаар сард ХЗДХЯ-д танхимаар хуралд оролцож ажилласан. | | | | |
| | | | | Түүнчлэн Дотоод хэргийн их сургууль, ЦЕГ-ын Мөрдөн байцаах алба, болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сан хамтран "Хүүхдээс үйлдсэн болон хүүхдийн эсрэг үйлдсэн гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, аливаа гэмт хэргийн хохирогч болон хүүхдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх" чиглэлээр багшийг сургагч багш бэлтгэх хөтөлбөрт д/х Ө.Сарангэрэл ажиллаж холбогдох санал, зөвлөмж, сургалтыг зохион байгуулсан. | | | | |
| 98 | 330 | "Эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилт" асуудлаар ..... авах зарим арга хэмжээний тухай 2024-12-18 Дугаар 2024 №09 ХЗБХ | 2.г.Шүүх шинжилгээний байгууллагын тоног төхөөрөмж, хүний нөөц, төсөв санхүүжилт, чиг үүргийн талаар Засгийн газраас бодлогын арга хэмжээ авч ажиллах; | Чиг үүргийн талаар: Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны А/09 дүгээр тушаалаар "Шүүх шинжилгээний байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, алба хаагчийн албан тушаал, цолны зэрэглэл"-ийг шинэчлэн баталсныг үндэслэн Шүүх шинжилгээний ерөнхий газрын даргын 2025 оны А/06 дугаар тушаалаар "Шүүх шинжилгээний ерөнхий газар, төв, газар, хэлтэс, хэсэг, тасаг, сувиллын орон тоо, цол, албан тушаалын зэрэглэл"-ийг шинэчлэн баталсан.<br>**Төсөв, санхүүжилтийн талаар:** 2025 онд Тус байгууллагын урсгал төсөв 61,397.1 сая төгрөг батлагдсан боловч Төсвийн тухай хуулийн тодотголоор тус байгууллагын төсвийг нийт 4,819.3 сая төгрөгөөр бууруулан баталсан. Мөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2025 оны ХЭГ/2940 албан бичгийн дагуу байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль, эрх зүй, бодлого, санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр тулгамдсан асуудлын талаар холбогдох мэдээллийг ХЗДХЯ-нд 01/10887, 01/12240, 01/12738 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн.<br>**Тоног төхөөрөмжийн чиглэлээр:** ХЗДХСайдын 2025 оны А/08 дугаар тушаалаар батлагдсан төлөвлөгөөний дагуу урсгал зардлын санхүүжилтээр 691.6 сая төгрөгийн шинжилгээний багаж техник хэрэгслийг, 964.3 сая төгрөгийн магадлан итгэмжлүүлэхэд шаардлагатай шинжилгээний багаж, тоног төхөөрөмжийг, 3,300.8 сая төгрөгийн шинжилгээний эм урвалж бодис, эмнэлгийн хэрэгслийг , хөрөнгө оруулалтын зардлын санхүүжилтээр нийт 6 багц тендэрийн худалдан авах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны газарт зохион байгуулж, 2,895.8 сая төгрөгийн гэрээг байгуулан албаны хэрэгцээнд шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийг хүлээн авсан. | Байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг сайжруулж, байгууллагын үйл ажиллагаанд олон улсын стандартыг нэвтрүүлж, итгэмжлэгдсэн лабораторид үзлэг, шинжилгээ хийж, дэвшилтэд техник, технологи, программ хангамж, арга, аргачлалыг ашиглан шинэ төрлийн шинжилгээг олон улсын жишигт нийцүүлэн хийсний үр дүнд цаашид "Нийгэмд шударга ёсыг бэхжүүлэх, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах шинжлэх ухааны баталгаа болох" эрхэм зорилгоо хэрэгжүүлэн шүүх шинжилгээний ажил үйлчилгээг иргэдэд жигд хүртээмжтэй, түргэн шуурхай, чанартай хүргэх нөхцөл, боломжийг сайжруулан ажилласан. | Нотломжийг цахим (pdf) хэлбэрээр хавсаргасан. | 100 | |
| | | | | Түүнчлэн Цахим технологийн шинжилгээний лабораторид 10 шинжилгээний программын лицензийн хугацааг сунгахад 238.7 сая төгрөг ("Форензик лаб Монголиа" ХХК), байгууллагын үйл ажиллагааны мэдээлэл технологийн аюулгүй байдлыг хангахад шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авахад 249.4 сая төгрөг ("Инфосолюшн" ХХК) тус тус зарцуулсан байна (нийт 488.1 сая.төг). | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 100 | 342 | Засгийн газарт чиглэл өгөх тухай 2025-05-14 Дугаар 2025№01 АБГББХ | 1.3.Шинэ төрлийн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт нэмэгдэж байгаа тул Монгол Улсад хориглосон, хязгаарласан, хяналтад байлгавал зохих, Монгол Улсын олон улсын гэрээний жагсаалтад ороогүй мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын жагсаалтыг тогтмол шинэчлэн, бүртгүүлэх, хяналтад авах; | Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд 2025.09.13-ны өдөр холбогдох саналыг цахимаар ХЗДХЯ-нд хүргүүлсэн.<br>Мөн Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хүрээнд 2025 оны 03, 09 дүгээр сард зохион байгуулагдсан нийт 3 удаагийн хэлэлцүүлэгт тус газрын Удирдлагууд болон хуулийн мэргэжилтэн нар оролцож, тухай бүр холбогдох саналыг танилцуулж ажилласан.<br>Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх Үндэсний хорооноос хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тус газраас тусгуулах ажлын саналаа ХЗДХЯ-нд 2025 оны 02/9031 дугаар албан бичгээр хүргүүлж ажиллалаа.<br>Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын шинжилгээний лабораторид 2025 онд нийт 4707 шинжилгээ хийснээс шинжээч эмчийн илгээх бичгээр 2688 шинжилгээ (6616 объект), эрх бүхий албан тушаалтны шинжилгээ хийлгэх шийдвэрээр 2019 (7352 объект) шинжилгээ хийж, дүгнэлт гарган ажилласан.<br>Түүнчлэн мансууруулах эм болон сэтгэцэд нөлөөлөх бодис тодорхойлох шинжилгээний "Agilent Technologies GC 7820G 5977E MSD" хийн хроматограф-масс спектрометр багажийн мэдээллийн санг 4155 шинэ төрлийн бодисын мэдээллээр баяжуулсан. | Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын шинжилгээний лабораторид 2025 онд НҮБ-ын 1961, 1971, 1988 оны конвенцын жагсаалтад ороогүй, Монгол Улсад өмнө нь бүртгэгдэж байгаагүй шинэ төрлийн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх 5 төрлийн бодис, бусад нэгдлүүдийг шинжилгээгээр тогтоож ажилласан бөгөөд цаашид шинжилгээний үр дүнг энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, хяналт тавихад ашиглана. | Санал хүргүүлсэн албан бичгийг цахим (pdf) хэлбэрээр хавсаргасан. | 100 | | |
| 103 | 353 | Засгийн газарт чиглэл өгөх тухай 2019-05-30 Дугаар 2019_104 | 1.12.Монгол Улсын хэмжээнд амиа хорлох оролдлого хийсэн болон амиа хорлосон тохиолдлыг бүртгэх мэдээллийн сан бүрдүүлж, холбогдох байгууллагуудын нэгдсэн сүлжээтэй болсны үндсэн дээр хүн амд үзүүлэх сэтгэлзүйн тусламж үйлчилгээг хүртээмжтэй болгох<br><br>Тайлбар: 2022 оны хагас жилийн тайланд хийсэн ХШҮ-ний дагуу энэхүү заалтыг ирүүлэхдээ | Шүүх шинжилгээний байгууллагын үйл ажиллагааны нэгдсэн систем буюу forensic.nfa.gov.mn цахим хуудасны шинжилгээний бүртгэлийн системийн тоон судалгаанаас үзэхэд 2025 оны жилийн эцсийн байдлаар дүүжлэлтээр нас барсан гэх 612, өөрийгөө хутгалж нас барсан гэх 3 хэргийн тохиолдол бүртгэгдсэн байна.<br>Оросын Холбооны Улсын Иркутск хотын Анагаах Ухааны Их Сургуульд 2025 оны 03 дугаар сарын 12, 13-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "Шүүх эмнэлгийн шинжилгээний орчин үеийн асуудлууд" сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хуралд тус газрын Чанарын баталгаажуулалтын хэлтсийн чанарын менежер Б.Ариунзул, Шүүх анагаах ухааны шинжилгээний газрын ахлах шинжээч эмч, цагдаагийн хошууч С.Эрдэнэцэцэг нар оролцож, "Амиа хорлосон тохиолдлуудын өнчин тархины морфологи өөрчлөлтийг хэмжил зүйн 3D программ ашиглан судалсан дүн" сэдэвт илтгэлийг амжилттай хэлэлцүүлсэн.<br>Тус хурлаар шүүх анагаах ухаан, эмгэг судлал, шүүх сэтгэц, шүүх химийн чиглэлээр орчин үеийн судалгааны үр дүн, хамтын ажиллагааны боломжуудыг хэлэлцэж, шүүх эмнэлгийн шинжилгээний | Энэ төрлийн гэмт хэргийн нотлоход тулгамдаж буй асуудал, олон улсын мэдлэг, туршлагыг судлах, цаашид хэрэгжүүлэх арга замыг эрэлхийлэхэд дэмжлэг үзүүлнэ. | Холбоос линк:<br><br>https://nfa.gov.mn/site/single/262<br><br>https://www.facebook.com/share/p/1a8Xae5hLV/?mibextid=wwXIfr | 100 | | |
| 107 | 359 | Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай 2018-02-05 Дугаар 2018_06/05 | 1.2.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн жагсаалтыг тагнуул, цагдаа, шүүхийн шинжилгээ, гааль, мэргэжлийн хяналтын болон холбогдох бусад байгууллагын саналыг авч НҮБ болон ДЭМБ-аас гаргасан жагсаалтыг үндэслэн тухай бүр шинэчлэн батлах санал боловсруулж, холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх | Монгол Улсад анх 2022 онд шинэ төрлийн мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисыг илрүүлснээс хойш өнөөг хүртэл нэр төрөл нь тасралтгүй өссөн үзүүлэлттэй байгаа тул тус газраас шинэ төрлийн мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын судалгаа хийсэн.<br>Хийгдсэн судалгааны хүрээнд цаашид эдгээр бодист "хэрхэн хяналт тавих, хууль бус эргэлтийг таслан зогсоох болон дотоодын түр жагсаалт батлах шаардлагатай эсэх талаар санал ирүүлэх, хамтран ажиллах" тухай 2025 оны 08/10727, 08/10728 дугаар албан бичгийг Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газарт тус тус хүргүүлэн ажилласан.<br>Үүний дагуу Нийслэлийн Прокурорын газрын 2025 оны Ц-2/6712 дугаар, Тагнуулын ерөнхий газрын Нийслэл дэх газрын 2025 оны 11/137 дугаар, Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газрын 2025 оны 19а/3520 дугаар албан бичгээр "Монгол Улсад түр хориглосон жагсаалт гаргах талаар холбогдох саналыг тусгах, хамтран ажиллах, ажлын хэсэг байгуулах" талаар хариу ирүүлээд байна.<br>Мөн 2025 оны 01 дүгээр сард Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас зохион байгуулагдсан "Донтох эмгэгтэй хүнд үзүүлэх тусламж, үйлчилгээ" сэдэвт сургалтад тус газрын 5 алба хаагч оролцсон.<br>Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2025 оны 04 дүгээр сард зохион байгуулагдсан "Согтуурах, мансуурах донтой хүнийг эмчлэх эмчилгээний өнөөгийн нөхцөл байдал, цаашдын чиг хандлага" сэдэвт хэлэлцүүлэгт 1 алба хаагч оролцож, санал солилцсон. | Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхдээ иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлын зөрчихгүй байх, олон улсын гэрээ, конвенцийн шаардлагад нийцүүлэн мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын чиглэлээр хийгдсэн судалгааны дүнг ашиглах, холбогдох ажил, арга хэмжээг зохион байгуулна. | Санал солилцсон албан бичгийг цахим (pdf) хэлбэрээр хавсаргасан. | 100 | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 287 | 677 | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 22 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-05-07 Дугаар 2025_22 | 22.21.5.5.Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн нөхцөл байдал, шалтгааныг судалж, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, таслан зогсоох үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлж, холбогдох үйл ажиллагааг эрчимжүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | Шүүх шинжилгээний ерөнхий газрын 2-р байранд хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлж, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх өрөөг тохижуулан ажиллаж байна.<br>Аймаг, орон нутагт Дорнод аймаг дахь Бүсийн шүүх шинжилгээний төв, Баян-Өлгий аймгийн Шүүх шинжилгээний хэлтсийн алба хаагчдын гэр бүл, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх зорилгоор ажлын байранд "Хүүхдийн өрөө"-г тохижуулан ашиглалтад оруулсан.<br>Шүүх шинжилгээний байгууллагаас гэр бүл, хүүхэд рүү чиглэсэн дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн. Үүнд: 2025 оны 09 дүгээр сард Ерөнхий боловсролын сургуулийн 120 сурагчдад "Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх" талаар мэдээлэл хийж, Өмнөговь аймаг дахь Бүсийн шүүх шинжилгээний төв 2025 оны 03 дугаар сард Даланзадгад, Гурвантэс, Ханбогд сумын Ерөнхий боловсролын дунд сургуулийн ахлах ангийн нийт 300 гаруй сурагчдад, Баян-Өлгий аймгийн Шүүх шинжилгээний хэлтэс 2025 оны 02-05 дугаар сард тус аймгийн Ерөнхий боловсролын 1, 2, 3, 6 дугаар ахлах сургууль, Дарын, Бастама сургуулийн ахлах ангийн 1345 сурагчдад хууль, эрх зүйн мэдлэг олгох сургалт, Говь-Алтай аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлөөс Эрдэнэцогт сумд зохион байгуулсан "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх өдөрлөг"-ийн үеэр тус аймгийн Шүүх шинжилгээний хэлтсээс Ерөнхий боловсролын 1-р сургуулийн 52 сурагчдад "Гэмт хэргээс хэрхэн урьдчилан сэргийлэх" талаар мэдээлэл хийж ажилласан байна. | Хүүхдэд сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэхдээ сэтгэл зүйг тайвшууруулах, өөрийгөө бүрэн илэрхийлэх нөхцөлөөр хангах, зөрөг уур амьсгал бүрдсэн орчин бүрдүүлэх нь сэтгэл зүйн тусламж үйлчилгээг 25 хувиар нэмэгдүүлдэг талаар судалгаа байдаг. Иймд үйлчлүүлж буй хүүхдүүдэд зөрөг уур амьсгал бүрдүүлэх, харилцагчийн сэтгэл татам байдлыг нэмэгдүүлж хувь хүнийг илүү нээлттэй болгох хүрээнд тус байгууллагын "Нэг цэгийн үйлчилгээний төв"-ийн өрөөг тохижуулан ажиллаж байна. | Нотломжийг цахим (pdf) хэлбэрээр хавсаргасан. | 100 | | |

ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗАР